



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 31 өдөр

Дугаар A/683.

Улаанбаатар хот

Г Нийслэлийн ерөнхий боловсролын Оюуны Ундраа сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 33,291,642.54 (гучин гурван сая хоёр зуун ерэн нэгэн мянга зургаан зуун дөчин хоёр төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурх бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Оюуны Ундраа сургууль (С.Нэргүйдаваа)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 16188 ширхэг нийт 33,291,642.54 (гучин гурван сая хоёр зуун ерэн нэгэн мянга зургаан зуун дөчин хоёр төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ном, сурх бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Оюуны Ундраа сургууль (С.Нэргүйдаваа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *С.Доржсаа* В.ОЮУМАА



Нийтэлэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны [Ц. дугаар сарын 3]. . -ны өдрийн Адмиралтэй дугаар Тушаалтын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгуулагын нэр: Нийстэгийн ерөнхий боловсролын Оюуны Ундраа цогцолбор сургууль